



# МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

ФУТЗАЛЫГ ХӨВГҮҮДИЙН U13 U14  
U16 УАШТ 2025  
U13 U14 U16 ЛИГ 2025

2024.12.25



## Нэг. Тэмцээний Зорилго

- 1.1 Монгол улсад хөлбөмбөгийн спортыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд МХБХ-ны “Футзалын Хөвгүүдийн U13, U14, U16 УАШТ болон /Лиг 2025”/цаашид Тэмцээн гэх/-ийг Монголын Хөлбөмбөгийн Холбоо /цаашид МХБХ гэх/ бодлогын хүрээнд зохион байгуулахад оршино.
- 1.2 Тэмцээнийг МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс /ТЗБХ/ удирдан, Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо /FIFA/, Азийн Хөлбөмбөгийн Холбоо /AFC/, МХБХ-ны дүрэм, журмууд болон бусад эрх зүйн бичиг баримтуудыг үндэслэн зохион байгуулна.
- 1.3 МХБХ-ны клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж, хөлбөмбөгийн хөгжлийг хот болон орон нутгийн хүүхэд залуучуудад хүргэнэ.

## Хоёр. Тэмцээний Зохион Байгуулалт

- 2.1 Тэмцээнд МХБХ-нд хөлбөмбөгийн байнгын үйл ажиллагаатай клубүүд оролцоно. Тухайн клуб нь хуулийн этгээд байх зайлшгүй шаардлагатай.
- 2.2 УАШТ холимог системээр зохион байгуулагдана.
- 2.3 Лиг нь нэг тойргийн системээр тойргийн тоглолтууд хийж тойргийн хүснэгтэнд бичигдэж буй багууд хоёр хуваагдаж нэг тойргийн тоглолтууд хийнэ.
- 2.4 Тэмцээнийг дараах насны ангилал болон хугацаанд зохион байгуулна. Үүнд:

Нас	Төрсөн Он сар	Тэмцээний үргэлжлэх хугацаа
U13 УАШТ	/2012.01.01-2012.12.31/	/2025.01.17-2025.01.22/
U14 УАШТ	/2011.01.01-2011.12.31/	/2025.01.19-2025.01.26/
U16 УАШТ	/2009.01.01-2010.12.31/	/2025.01.19-2025.01.27/
U13 Лиг	/2012.01.01-2012.12.31/	/2025.02.03-2025.03.31/
U14 Лиг	/2011.01.01-2011.12.31/	/2025.02.01-2025.03.17/
U16 Лиг	/2009.01.01-2010.12.31/	/2025.02.02 -2025.03.25/

№	Насны ангилал	Багийн бүрэлдхүүн	Тоглолтонд оролцох тамирчдын тоо	Албаны хүний тоо	Тоглолтын хугацаа
1	13 нас УАШТ	25	16	4	15-10-15
2	14 нас УАШТ	25	16	4	15-10-15
3	16 нас УАШТ	25	16	4	15-10-15

№	Насны ангилал	Багийн бүрэлдэхүүн	Тоглолтонд оролцох тамирчидын тоо	Албаны хүний тоо	Тоглолтын хугацаа
1	13 насны Лиг	25	16	4	15-10-15
2	14 насны Лиг	25	16	4	15-10-15
3	16 насны Лиг	25	16	4	15-10-15

**2.5** Тоглогчдын тоо 3 хүрэхгүй тохиолдолд тоглолтыг цуцалж эсрэг багт 5-0 буюу техникийн хожил өгнө.

**2.6** Нас насны УАШТ-нээс цааш шалгарсан нийт 8 баг нь нэг тойргийн системээр өрсөлдөх ба тойргийн системийн дараагаар хүснэгтийн эхний дөрөв мөн хүснэгтийн 5 - 8 дугаар байранд бичигдэж буй багууд хоорондоо тойргоор тоглоно.

**2.7** Тэмцээнд оролцох бүх тоглогчид “FIFA Connect” системд бүртгэлтэй байна.

**2.8** Тэмцээнд оролцох баг нь тэмцээний мэдүүлгийг үнэн зөв бөглөж, хариуцлагыг бүрэн хүлээнэ. Баг нь өөр клубт бүртгэлтэй, гэрээтэй тоглогчийг мэдүүлэгт тусгах, тоглох эрхгүй тоглогчийг тоглолтод оруулсан тохиолдолд клубт зохих хариуцлага тооцно.

**2.9** Тэмцээний мэдүүлгийг ТЗБХ-ээс шалгахгүй бөгөөд асуудалтай тоглогч тоглуулсан тохиолдолд 2.6 заалтын дагуу арга хэмжээ авч МХБХ-ны Сахилгын дүрмийн дагуу шийтгэнэ.

**2.10** Баг нь МХБХ-ны тэмцээн зохион байгуулалттай холбогдох бүхий л дүрэм, журам, заавартай сайтар танилцаж тэдгээр шаардлагуудыг зайлшгүй биелүүлсэн нөхцөлд тэмцээнд оролцох эрх болон үүрэгтэй.

**2.11** Баг нь МХБХ-ны “Тэмцээн зохион байгуулах журам”-ын бүртгэл ба мэдүүлэгтэй холбоотой шаардлагуудыг бүрэн хангаагүй тохиолдолд ТЗБХ тухайн багийг тэмцээнд оруулахгүй байх эрхтэй.

**2.12** МХБХ-ноос зохион байгуулсан тэмцээний тоглолт бүрт шүүгчийн шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

**2.13** Тоглолтын явцад шүүгчийн хараа хяналтаас гадуур явагдсан сахилга баттай холбоотой асуудлыг тоглолтын бичлэг дээр үндэслэн ТЗБХ нөхөж шийдвэр гаргана. Гэхдээ энэ заалт нь зөвхөн хуудас, сахилга болон ёс зүйн асуудалтай холбоотой байна. Албан ёсны эрх бүхий

TV, МХБХ-ны албан ёсны бичлэг болон баталгаат бусад эх сурвалжит утас/камерийн бичлэг дээр үндэслэнэ.

- 2.14** Тэмцээний тоглолтод хамааралтай МХБХ-ны дүрэм, журамд тусгагдаагүй асуудлыг ТЗБХ өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.
- 2.15** ТЗБХ-ийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг ТЗБХороо болон шаардлагатай бол эрх зүйн байгууллагууд шийдвэрлэнэ.
- 2.16** Шүүгч болон шүүлттэй холбогдсон үйл ажиллагааг Шүүгчийн хорооноос баталсан журмын дагуу зохицуулна. МХБХ-ны тэмцээнд Шүүгчийн хэлтсээс бэлтгэгдсэн тангараг өргөсөн шүүгч нарыг томилно.
- 2.17** МХБХ-ны тэмцээнд шүүх шүүгч нарыг Шүүгчийн хэлтсээс томилогдсон Хянагч шүүгч хянаж ажиллана.
- 2.18** Тэмцээний Тоглолт зохион байгуулагчийг ТЗБХ томилно. Тоглолт зохион байгуулагч нь ТЗБХ-ийг төлөөлөх бүрэн эрхтэй.
- 2.19** Тэмцээнд оролцож буй нийт баг тоглогчид, хөлбөмбөгийн спортыг эвсэг, нөхөрсөг, шударга, сонирхолтой байлгахын төлөө “FAIR PLAY” зарчмыг тэмцээний түрш мөрдөх үүрэгтэй.
- 2.20** МХБХ-ны ТЗБХ шар болон улаан хуудасны өнжүүлэх шийтгэлүүдийг тэмцээний онцлогоос хамаарч шууд ногдуулах эрхтэй.
- 2.20.1 Тэмцээнд тоглогч эсвэл багийн албаны хүний шар хуудас 2 болсон тохиолдолд тухайн тоглогч эсвэл албаны хүн дараагийн 1 тоглолт өнжинө.
- 2.20.2 Илт гоол орох боломжийг алдагдуулах болон тоглолтын явцад 2 дахь шар хуудас авах эсвэл ноцтой алдаа гаргасан гэж үзвэл 1 тоглолт өнжүүлнэ.
- 2.20.3 Хэрэв тоглогч болон албаны хүн 1 тоглолтод 2 дараалсан шар хуудас авсан тохиолдолд дараагийн 1 тоглолт өнжинө.
- 2.21** МХБХ-ны тэмцээний үеэр ТЗБХ-т хандсан хүсэлт, гомдлыг тоглолт дууссан цагаас хойш 2 цагийн дотор зөвхөн бичгээр хүлээн авна. Харин тоглолтын шүүлттэй холбоотой аливаа гомдлыг хүлээж авахгүй. Хэрэв дээрх байдлаас өөр хэлбэрээр /зүй бусаар/ хүсэлт гомдлыг тоглолтын дараа илэрхийлсэн тохиолдолд тухайн клуб, баг, албаны хүн, тоглогчийг ТЗБХ-ийн зүгээс МХБХ-ны Сахилгын болон Ёс зүйн хороонд шилжүүлнэ.
- 2.22** Тэмцээний заавар гарснаас хойш 7 хоногийн хугацаатайгаар клубүүдээс албан ёсны санал/хүсэлтүүдийг хүлээн авна.
- 2.23** Тоглолт наймаалцах, тэмцээний явцад ямар нэгэн байдлаар өөрийн багтаа ашигтайгаар нөлөөлөх үйлдэл хийх, бусад багуудын эрх ашигт ноцтойгоор халдсан, тэмцээний зохион байгуулалтанд хүндрэл учруулсан нь нотлогдвол FIFA, AFC, МХБХ-ны “Сахилгын дүрэм”, “Ёс зүйн дүрэм”-ийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### **Гурав. Дасгалжуулагч ба үүрэг хариуцлага**

3.1 Багийн, ахлах болон туслах дасгалжуулагч, хариуцсан чиглэлээ төлөөлөх бүрэн чадвартай байж эрх, үүргээ ухамсарласан байна.

3.2 Тэмцээнд оролцох багийн дасгалжуулагч нь дараах ангилалтай байна. Үүнд:

- Ахлах болон туслах дасгалжуулагч - MFF Futsal Level-1 ба түүнээс дээш,

- 3.3 Дасгалжуулагч нь зөвхөн МХБХ-ны Техникийн хэлтсээс олгосон хүчинтэй “Дасгалжуулагчийн лиценз”-тэй байж тоглолтод оролцоно. Хүчинтэй лицензтэй дасгалжуулагч байхгүй тохиолдолд тоглолтыг эхлүүлэхгүй. Тоглолтыг цуцалж эсрэг багт 5-0 дүнгээр хожил олгоно (ТЗБЖ-ын 12.5).
- 3.4 Техникийн бүсээс чөлөөлөгдсөний дараа дасгалжуулагч нь тусгайлан бэлдсэн суудлаас тоглолтой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд тухайн албаны хүнийг МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу торгоно.
- 3.5 Дасгалжуулагч нь тоглолтонд оролцоогүй, сахилга болон ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд, Техникийн хэлтсээс тухайн хүнд сануулга өгөх болон лицензийг түтгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна. Ноцтой зөрчил гаргасан тохиолдолд тухайн дасгалжуулагчийн эрхийг шууд хүчингүйд тооцох ба нэмэлтээр МХБХ-ны Сахилга ба Ёс Зүйн Хороонд шилжүүлнэ. Шийтгэлийн хугацаа болон торгуулийг тэдгээр эрх зүйн байгууллагууд тогтооно (ТЗБЖ-ын 10.6).
- 3.6 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь үзэгчдийн суудлаас тоглолтой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг МХБХ-ны “Сахилгын дүрэм”-ийн дагуу торгоно.
- 3.7 Дасгалжуулагч нь клубтэй хийсэн гэрээгээ ТЗБХ-т заавал бүртгүүлнэ. Хэрэв тэмцээний явцад дасгалжуулагч өөрчлөгдсөн тохиолдолд шинээр бүртгүүлэх дасгалжуулагчийн гэрээг заавал бүртгүүлнэ (ТЗБЖ-ын 12.13).

## Дөрөв. Бүртгэл, шилжилт хөдөлгөөн

- 4.1 Оролцох багийн мэдүүлгийг 2025 оны 01 сарын 06-ны өдрийн 17:00 цагаас өмнө [meduulegmff@gmail.com](mailto:meduulegmff@gmail.com) хаягаар хүлээж авна. Мэдүүлгийг эх хувиар нь багууд Тэмцээний Зөвлөгөөн дээр авчирна.
- 4.2 Тэмцээний зөвлөгөөн 2025 оны 01 сарын 07-ны өдрийн 17:00 цагаас МХБХ-ны сургалтын танхимд болно.
- 4.3 Тоглогчдын эрүүл мэндийн үзлэгт х
- 4.4 амруулсан албан бичгийг мэдүүлэгтэй хамт ТЗБЖ Хавсралт 2-ыг хавсаргаж ирүүлнэ.
- 4.5 Дараах шаардлагуудыг хангаагүй мэдүүлгийг бүртгэж авахгүй. Үүнд:
- 1) Цээж зураг / сүүлийн 6 сарын хугацаанд авахуулсан байна / ,
  - 2) Мэдүүлэг баталгаат гарын үсэггүй,
  - 3) Хувийн дугааргүй,
  - 4) Регистрийн дугааргүй,
  - 5) Овог, нэр дутуу,
  - 6) ТЗБЖ-ын Хавсралт 1 бүрдүүлээгүй,
  - 7) ТЗБЖ-ын Хавсралт 2 бүрдүүлээгүй,
  - 8) Клубийн харилцах цахим хаяггүй,
  - 9) Холбоо барих утасны дугааргүй,

## Тав. Дүн гаргалт

### 5.1 Дараах байдлаар хэсгийн тоглолтын дүнг гаргана.

Хэрвээ 2 ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна:

- a) Хоорондын тоглолтын дүнгээр,
- b) Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
- c) Хоорондын тоглолтын оруулсан бөмбөгний ихээр,
- d) Хүснэгтийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
- e) Хүснэгтийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр,
- f) Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор,
- g) Fair Play оноо тодруулах зарчмаар
- h) Шодолтоор

## Зургаа. Тэмцээний шагнал урамшуулал

6.1 УАШТ тэмцээний эхний 4 байр эзэлсэн багт Өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал олгоно.

- Нэгдүгээр байрын шагнал:

Шилжин явах цом, өргөмжлөл, алтан медаль, 2,000,000 төгрөг

- Хоёрдугаар байрын шагнал:

Мөнгөн медаль, өргөмжлөл 1,500,000 төгрөг

- Гуравдугаар байрны шагнал:

Хүрэл медаль, өргөмжлөл, 1,000,000 төгрөг

- Дөрөвдүгээр байрны шагнал:

Өргөмжлөл, 500,000 төгрөг

6.2 Тэмцээний эхний 8 байрууд эзэлсэн багуудад тухайн насны лигт оролцох эрхийг олгоно. Оролцох боломжгүй клубын оронд тэмцээнд эзэлсэн байрлалын дарааллаар дараах клубт лигийн эрхийг шилжүүлнэ.

6.3 Тэмцээний шилдэг тоглогчдыг шалгаруулж, урамшуулна.

Шилдэг хаалгач: цом, батламж, дурсгалын зүйл,

Шилдэг тоглогч: цом, батламж, дурсгалын зүйл,

Шилдэг довтолгоч: цом, батламж, дурсгалын зүйл.

6.4 Лигийн тэмцээний эхний 3 байр эзэлсэн багт Өргөмжлөл, медаль, мөнгөн шагнал олгоно. 4-8-р байрны багууддаа өргөмжлөл олгоно.

- Нэгдүгээр байрын шагнал:

Шилжин явах цом, өргөмжлөл, алтан медаль, 3,000,000 төгрөг

- Хоёрдугаар байрын шагнал:

Мөнгөн медаль, өргөмжлөл 2,000,000 төгрөг

- Гуравдугаар байрны шагнал:

Хүрэл медаль, өргөмжлөл, 1,500,000 төгрөг

- Дөрөвдүгээр байрны шагнал: Өргөмжлөл, 1,000,000 төгрөг
- Тавдугаар байрны шагнал: Өргөмжлөл, 800,000 төгрөг
- Зургаадугаар байрны шагнал. Өргөмжлөл, 700,000 төгрөг
- Долоодугаар байрны шагнал. Өргөмжлөл 600,000 төгрөг
- Наймдугаар байрны шагнал. Өргөмжлөл 500,000 төгрөг

6.5 Тэмцээний шилдэг тоглогчдыг шалгаруулж, урамшуулна.

Шилдэг хаалгач: цом, батламж, дурсгалын зүйл,

Шилдэг тоглогч: цом, батламж, дурсгалын зүйл,

Шилдэг довтлогч: цом, батламж, дурсгалын зүйл.

## МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН  
ХОЛБОО

ЛОГО



"....." КЛУБЫН МЭДҮҮЛЭГ.

ХУУДАС

1

ТЭМЦЭЭН

/ ТЭМЦЭЭНИЙ НЭР /

БАГИЙН АЛБАНЫ ХҮМҮҮСИЙН МЭДҮҮЛЭГ



ОВОГ  
НЭР  
АЛБАН ТУШААЛ  
ИРГЭНШИЛ  
УТАСНЫ ДУГААР  
ЕМАЙЛ ХАЯГ  
ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

Баттулга  
Эрдэнэбат  
Ахлах Дасгалжуулагч  
Монгол  
**99984421**  
[meduulegmff@gmail.com](mailto:meduulegmff@gmail.com)  
**AFC A**

СҮҮЛИЙН 3 САРД  
АВАХУУЛСАН  
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ  
НЭР  
АЛБАН ТУШААЛ  
ИРГЭНШИЛ  
УТАСНЫ ДУГААР  
ЕМАЙЛ ХАЯГ  
ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

СҮҮЛИЙН 3 САРД  
АВАХУУЛСАН  
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ  
НЭР  
АЛБАН ТУШААЛ  
ИРГЭНШИЛ  
УТАСНЫ ДУГААР  
ЕМАЙЛ ХАЯГ  
ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

СҮҮЛИЙН 3 САРД  
АВАХУУЛСАН  
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ  
НЭР  
АЛБАН ТУШААЛ  
ИРГЭНШИЛ  
УТАСНЫ ДУГААР  
ЕМАЙЛ ХАЯГ  
ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

СҮҮЛИЙН 3 САРД  
АВАХУУЛСАН  
ЦЭЭЖ ЗУРАГ

ОВОГ  
НЭР  
АЛБАН ТУШААЛ  
ИРГЭНШИЛ  
УТАСНЫ ДУГААР  
ЕМАЙЛ ХАЯГ  
ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ

Page 1



## МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Ш/х-259, Улаанбаатар-210646. Монголын Хөлбөмбөгийн Холбооны төв.  
Хан-уул дүүрэг, 15-р хороо, Улаанбаатар, Монгол Улс.  
Утас: 345964-17, Факс: 345966



### МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

"....."БАГИЙН ХУВЦАСНЫ МЭДҮҮЛЭГ.

